

АЖЛЫН БАЙР ХАЙХ (D-10)

ОЛГОХ ХҮРЭЭ:

Их, дээд сургуулийн багш (E-1), Ярианы ментор (E-2), Судалгаа (E-3), Технологийн зааварлагч (E-4), Мэргэжлийн ажил эрхлэлт (E-5), Урлагийн тоглолт (E-6), Тусгай үйл ажиллагаа (E-7) зэрэг ангилалд хамаарах салбарт ажилд орох зорилгоор сургалтанд суух, Ажлын байр хайх гэж буй иргэн

ВИЗНИЙ ТӨРӨЛ:

6 сар хүртэлх хугацаатай нэг удаагийн виз

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД	
1.	Виз мэдүүлгийн маягт: Цээж зураг (3.5 x 4.5 см хэмжээтэй, сүүлийн 6 сарын дотор авахуулсан) визний хураамж 60 ам.доллар
2.	Гадаад паспорт, хуулбар 1 хувь,
3.	Ажил байдлын тодорхойлолт * эсхүл боловсролын гэрчилгээ **
4.	Дүнгийн тодорхойлолт – БНСУ д их дээд сургууль төгсөгчдөд хамаарна
5.	Судалгааны байгууллагын тодорхойлолт* (Судалгааны байгууллагад судалгаа хийж дуусгасан хүнд хамаарна),
6.	Ажлын байр хайх төлөвлөгөө
7.	Ажлын байр хайх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт Өөрийн, эсхүл эцэг, эхийн Монгол дахь дансны хуулга(виз мэдүүлэх өдрөөс өмнө 14 хоногийн дотор авсан байх) Дансны хуулга авах өдрийн байдлаар 4,500 ам.доллартай дүйцэхүйц мөнгийг 30 хоногоос дээш хугацаагаар заавал байршуулах. Материал шалгах үед дансны хуулган дээрх хадгаламж нээснээс хуулга авсан өдөр хүртэлх хугацаа 30 хоног хүрэхгүй байх тохиолдолд санхүүгийн чадвар хангахгүйд тооцно. (Хадгаламжийн журам зөрчсөн) Ø Дансны хуулга дээр хуулга авсан он, сар, өдрийг тодорхой тэмдэглэгдсэн байх. Ø Эцэг, эх нь нас барсан тохиолдолд төрсөн ах, эгч, дүүгийн дансны хуулга байж болно.
8.	Гэрлэлтийн лавлагаа
9.	Цагдаагийн газрын тодорхойлолт (18 нас хүрсэн иргэн болон анх виз мэдүүлж бай иргэнд хамаарна)
10.	Сүрьеэгийн шинжилгээний бичиг (БНСУ-ын ЭСЯ-аас заасан эмнэлэгээс авах)

*тэмдгээр тэмдэглэгдсэн нөхцлүүдийн дэлгэрэнгүйг VISA FINDER аас лавлана уу.